



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 3 дугаар
сарын 05 өдөр

Дугаар А-32

Улаанбаатар
107

Нийгмийн халамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай

1. Нийгмийн халамжийн тухай Монгол улсын хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг хүчингүй болсонтой холбогдуулан нийслэлийн нутаг дэвсгэрт нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн халамжийн сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, дүүргүүдийн нийгмийн халамжийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж удирдах үүрэг бүхий Нийгмийн халамжийн албыг 1997 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн нийслэлийн Засаг даргын харъяанд хэрэгжүүлэгч агентлагийн хэлбэрээр байгуулж ажиллуулсугай.

2. Нийслэлийн Нийгмийн халамжийн албаны даргаар Авирмэдийн Эрдэнэбаатарыг томилж, сарын үндсэн цалинг 28600 төгрөгөөр тогтоож, нэмэгдлийг үндсэн цалингийн 10 хувиар бодож олгосугай.

3. Нийгмийн халамжийн сангаас нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгох, нийгмийн халамжийн болон өсрэмжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг 1997 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дүүргийн Нийгмийн халамжийн төвд хариуцуулахыг Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Баянгол, Сонгино-Хайрхан, Баянзүрх, Налайх дүүргийн Засаг даргад, байцаагч-нягтлан бодогч ажиллуулахыг Багануур, Багахангай дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Нийслэлийн нийгмийн халамжийн албаны болон Халамжийн төвийн үлгэрчилсэн дүрмийг энэ оны 3 дугаар сард багтаан боловсруулж Засаг даргын зөвлөлийн хуралд оруулахыг Нийгмийн бодлогын хэлтэс (н.Хадхүү), Нийгмийн халамжийн алба (н.Эрдэнэбаатар)-нд, нийгмийн халамжийн төвийн дүрмийг батлан мөрдүүлэхийг дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Дүүргийн халамжийн төвийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийг хүлээлцэх, нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн халамж хариуцсан байцаагчдыг тухайн дүүргийн Халамжийн төвд шилжүүлж ажиллуулахыг Нийгмийн даатгалын газар (н.Сумаахүү), Нийгмийн халамжийн алба (н.Эрдэнэбаатар) -нд даалгасугай.

6. Нийслэлийн хэмжээнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлтүүдийг хугацаанд нь олгох, үйлчилгээг хөнгөн шуурхай болгоход байнга хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (н.Хадхүү)-т үүрэг болгосугай.

7. Нийслэлийн нийгмийн халамжийн алба болон дүүргийн халамжийн төвийн төсвийг хянаж санхүүжүүлж байхыг Санхүүгийн хэлтэс (н.Гонгор)-т даалгасугай.

8. Нийслэлийн нийгмийн халамжийн албаны орон тооны хязгаарыг 5 хүртэл, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгино-Хайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Налайх дүүргийн халамжийн төвийн орон тооны хязгаарыг 12 хүртэл, Багануур, Багахангай дүүрэгт байцаагч-нягтлан бодогч тус бүр нэг байхаар тогтоосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ